

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Үнэлгээний тайлбар	Хяналтаас хасах саналтай эсэх
УИХ-ын тогтоол							
10	13	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37	а/бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;	Сургуулиуд эрсдэлийн өөрийн үнэлгээг улирал тутам хийж хэвшсэн бөгөөд 2026 онд давхардсан тоогоор 40 удаа үнэлгээ хийж, давхардсан тоогоор 328 эрсдэл илрүүлснээс 252 эрсдэл буюу 76.8%-ийг бүрэн арилгаад байна. Сургуулийн орчны аюулгүй байдлын стандартыг 46 асуулгаар үнэлэхэд 79.3%-тай хангагдсан бөгөөд үүнээс их эрсдэлтэй 2 (Сэргэлэн, Чулуунхороот сумын ЕБС), дунд эрсдэлтэй 7, бага эрсдэлтэй 14 сургууль үнэлэгдлээ. Дотуур байрны орчны үйлчилгээний стандартын үнэлгээнд хамрагдсан байрны 5 нь дунд, 10 нь бага эрсдэлтэй гарсан бөгөөд 37 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дотуур байруудын 46.7-60.0% нь биеийн тамирын талбай, дасгалын хэрэгсэл, галын дохиололгүй, 40.0-53.3% нь дулаан, ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй, 46.7% нь номын сангийн ном хангамж дутмаг, 40% нь хөгжлийн ерөөндөө хөгжим, буйдангүй, 13.3% нь зурагтгүй, 60.0% нь компьютер болон сэтгэхүй хөгжүүлэх тоглоом наадгай хангалтгүй байгаа нийтлэг зөрчил илэрлээ. Мөн гүйцэтгэлийн үнэлгээний асуумжийн дагуу орчны эрсдэлийг цэцэрлэгийн түвшинд 28, сургуулийн түвшинд 62 асуумжаар үнэлэхэд сургуулийн өмнөх байгууллагууд 73-91%, ЕБС-иуд 85-92%-ийн биелэлттэй гарч, зөрчлийг тухай бүр засах чиглэл өгөв. Эрүүл ахуйн стандартын үнэлгээнд төрийн өмчийн 22 сургууль, 16 дотуур байр 100% бүрэн хамрагдаж, хүүхдийн амьдрах орчин, ариун цэвэр, хоол үйлдвэрлэл, ус хангамжийг шалган, илэрсэн нийтлэг 32 зөрчлийг арилгуулах чиглэл өгсөн байна. Стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд 42 удирдах ажилтан, эмч, албан хаагчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, эрсдэлгүй, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлээ.			Үгүй
	14		б/хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах;	"Тусгай хэрэгцээт боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд хөгжлийн ялгаатай хүүхэдтэй ажиллаж буй багш нарыг чадавхжуулах цуврал сургалтуудыг зохион байгууллаа. Монголын тусгай Олимпын хороотой хамтран оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийг урлаг, спортоор дамжуулан нийгэмшүүлэх, бие бялдрыг нь чийрэгжүүлэх зорилгоор "Бүжгийн багш, дасгалжуулагч бэлтгэх" сургалтад 21 цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 26 багшийг хамруулав. Мөн Дэлхийн Зөн Монгол ОУБ болон "Энэрлийн түүчээ" ТББ-тай хамтран зохион байгуулсан "Модуль-4" сургалтад 119 багш хамрагдсанаас 25 нь "Сургагч багш"-аар бэлтгэгдэж, арга зүйн зөвлөгөө өгөх дотоод нөөцийг нэмэгдүүллээ. Түүнчлэн аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэд, тэдний гэр бүлийг дэмжих зорилгоор БЕГ-аас зохион байгуулсан цахим сургалтад 191 багш, 94 эцэг эхийг хамруулж, 24 хүнд ганцаарчилсан мэргэжлийн зөвлөгөө мэдээлэл хүргэв. 2026 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 14 сургуулийн 125 багш, 16 цэцэрлэгийн 150 багш буюу нийт 275 багшид нэмэгдэл хөлс олгоод байна. Үүнд нийт 102.0 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 51.5 сая төгрөгөөр буюу 2 дахин нэмэгджээ. Эдгээр цогц арга хэмжээ нь тусгай хэрэгцээт боловсролын хүртээмж, хүний нөөцийн тогтвортой байдлыг бататгаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарын мэргэжлийн чадавх, хариуцлага, урам зоригийг дээшлүүлсэн бодит дэмжлэг боллоо.	100		Үгүй

УИХ-ын байнгын хорооны тогтоол

14	21	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2020-08-26 Дугаар 2020.08.26 №01 ИЦББХ	Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах	Ерөнхий боловсролын төрийн өмчийн 23 сургууль МЦХ-той гэрээгээ үргэлжлүүлэн, сургууль бүр 20 Mbps-ээс дээш хурдаар мэдээлэл хүлээн авах техникийн нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн. Хэрлэн сумын хэмжээнд Тасалдал, доголдол гараагүй болно. Орон нутгийн сургуулиудад тоон сувгийн үйлчилгээг “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн дэд бүтцээр дамжуулан хүргэдэг. 2026 оноос эхлэн L2/PTN технологийд үе шаттайгаар шилжүүлж байна. Уг шилжилтийг хэрэгжүүлснээр одоогийн 100 Mbps багтаамжийг 1 Gbps хүртэл нэмэгдүүлэх шаардлагатай SFP модулийг Боловсролын газраас худалдан авч, Хэрлэн сумын сургуулиудын интернэтийн хурдыг нэмэгдүүлэх боломж бүрдүүлсэн.	100		Үгүй
16	24	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх;	Дорнод аймгийн боловсролын байгууллагуудын хоол үйлдвэрлэл, үйлчилгээг MNS 7005:2023 стандарт шаардлагад нийцүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байна. Материаллаг баазыг бэхжүүлэх хүрээнд 2026 онд Орон нутгийн хөгжлийн сангаас 156.9 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэж, 12 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр бэлтгэл ажлыг хангалаа. Мөн Дээрээт олон улсын байгууллагын 100.8 сая төгрөгийн дэмжлэгээр Хэрлэн сумын 1, 8-р сургуулийн гал тогоог иж бүрэн шинэчилснээр хоол үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, технологийн хугацаа хэмнэгдэн, эрүүл аюулгүй хоолоор үйлчлэх нөхцөл бүрдэв. 2026 оны байдлаар цэцэрлэгийн 96.7 хувь, сургуулийн 86.3 хувь нь тоног төхөөрөмжөөр хангагдсан хэдий ч судалгаагаар 2027 онд 13 сургууль, 18 цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн зарим тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дуусч байгаатай холбоотой нөхөн хангалт хийх хэрэгцээ байна.	100		Үгүй
	25		орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;	Сургууль, цэцэрлэгийн хоол хүнсний чанар, хүртээмжид хяналт тавих чиглэлээр сургуулийн өмнөх боловсролын 5 байгууллага, ерөнхий боловсролын 9 сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчинд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар стандартын шаардлага хангаж буй эсэхийг үнэлж, илэрсэн зөрчлийг арилгах, эрүүл ахуйн горимыг мөрдүүлэх чиглэлээр холбогдох албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав. Хоол үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад давхардсан тоогоор 191, ерөнхий боловсролын сургуульд 129 аж ахуйн нэгж, иргэнтэй хамтран ажиллаж байна. Үүнээс орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд орон нутгийн 5 аж ахуйн нэгжийг ханган нийлүүлэлтэд тогтмол хамруулж байна. Нийт түүхий эдийн зардлын 60 хувийг дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүнд зарцуулж, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжин ажиллалаа. Ерөнхий боловсролын 22 сургуулийн 40.9 хувь буюу 9 сургууль туслах аж ахуйг хөгжүүлж байна. Орон нутгийн төсвийн 20 сая төгрөгийн санхүүжилт болон хандивын тусламжаар нийт 544 кв хүлэмж болон ил талбайг ашиглаж байна. Туслах аж ахуйн хүрээнд тарьж ургуулсан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг хичээл сургалтын үйл ажиллагаанд туршилт болгон ашиглахаас гадна сургуулийн хоол үйлдвэрлэлд тогтвортой нийлүүлж байна	100		Үгүй

	50		Орон нутагт хэрэгжүүлж буй Сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламж барих төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад тогтмол хяналт тавьж, ашиглалтыг сайжруулан ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгох;	Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны боловсон ариун цэврийн байгууламж (Дашбалбар сумтай хамтран), Сургалтын байгууллагын ариун цэврийн өрөөг ялгаатй хэрэгцээт суралцагчдад зориулан тохижуулахад шаардлагатай бараа материал худалдан авах (Хэрлэн сум) ажлыг 189.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	100		Үгүй
	51		2025 онд багтаан ариун цэврийн байгууламжийн Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн барилга,	Баян-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2 салбар бүлэг, ерөнхий боловсролын бага сургуулийн ариун цэврийн байгууламж, гүйцэтгэл 60% Ажлыг эрчимжүүлэх сайжруулах чиглэлээр Боловсролын ерөнхий газар, Барилга хөгжлийн төвтэй хамтран 2 удаа, Зураг төсвийн компанитай хамтран 1 удаа газар дээр нь танилцаж гэрээ цуцлах санал хүргүүлсэн бөгөөд Боловсролын яамнаас гэрээ цуцласан гэсэн хариу мэдээлэл өгсөн.	70	Төсөв шийдэгдсэн боловч гүйцэтгэгч компаниас болж ашиглалт орох хугацаа хойшлоод	Үгүй
	56		Монгол хүний сэтгэлгээ үнэт зүйл, шинжлэх ухааны судалгаанд үндэслэн нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэхэд чиглэсэн албан болон албан бус сургалтын хөтөлбөрийн агуулгыг боловсруулан сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнг нэгтгэн жил бүр тайлагнаж ажиллах;	Монголын нууц товчоо, түүхэн зүтгэлтнүүд, тусгаар тогтнолын түүхийг зөвхөн цээжлэх биш, аялгуулан унших, дүрд тоглох, түүхэн кино хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг сонирхолтой аргаар зааж сургав. Ерөнхий эрдмийн хичээлийн интеграци: Уран зохиол, хөгжим, дүрслэх урлагийн хичээлүүдийг хооронд нь уялдуулж, сурагчдад монгол ахуй, уламжлалт зан заншлыг цогцоор нь ойлгох нөхцөлийг бүрдүүлсэн. Тус үйл ажллагаанд давхардсан тоогоор 2840 суралцагч хамрагдаж Сурагчдын авьяас чадвар хөгжиж, соёлын өвийг тээгч болох суурь тавигдсан байна.			Үгүй
Ерөнхийлөгчийн зарлиг							
34	61	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион	БГ, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөл Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллага, Ерөнхий боловсролын 27 сургууль бүгд гадна хаяг болон анги танхимын хаягжилтыг 100 хувь хос бичгээр бичсэн. Хэрлэн сумын гудамж, замын чиглэлийг 100 хувь хос бичгээр бичиж байршуулсан. Үндэсний бичгийг заах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажилд хувь нэмэр оруулан ажиллаж буй Биений тамир, спортын газрын бичиг хэргийн ажилтан Б.Энхжаргал, Хэрлэн сумын 5 дугаар сургуулийн монгол хэл, бичгийн багш М.Хэнчбиш нарыг Боловсролын яамны шагнал “Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч” тэмдэгээр шагнав.	100		Үгүй

35	62	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Мэргэжлийн байгууллагын зөвлөмжөөр Хэрлэн сумын 1, 8, 11, Хан-Уул сургуулийн ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт сургуулийн хүүхэд хамгааллын баг, хоол зүйч нар хамтран ЭМС-ын А/370 дугаар тушаал "Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт батлах тухай" тушаалыг танилцуулан, цаашид тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг 8 аж ахуй нэгжид мэдээлэл хүргэж ажилласан.	100		Үгүй
60	112	2026 оныг “Боловсролыг дэмжих жил болгон зарлах тухай 2025-04-02 Дугаар 2025_158	3.Боловсролыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хүртээмжийг нэмэгдүүлэх, удирдлага, албан хаагчдыг дэмжих чиглэлээр 5325 суралцагчид мэргэжлийн чиг баримжаа олгох өдөрлөг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан 39.5 сая төгрөгийн хүртээмжийн орчин бүрдүүлэв. Хувилбарт сургалтын "Гэрт хүрэх багц" төслийн гэрээ байгуулах шатанд орж, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг аргын чиглэлээр олон арга хэмжээ зохион байгуулж 1000 гаруй хүнийг хамруулав. 22 сургуулийн 2303 хүүхдийн үндэсний бичгийн цахим бичвэрийг байршуулж хэрэглээний орчинг бүрдүүлэв. Сурах орчныг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр ОНХС болон олон улсын байгууллагын санхүүжилтээр нийт 300 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 15 гаруй сургууль, цэцэрлэгт нийлүүлж, хоол үйлчилгээний стандартыг дээшлүүлэв. Улсын физикийн XXXVII олимпиадыг 200 сая төгрөгийн санхүүжилтээр орон нутагт өндөр түвшинд зохион байгуулж, "Дорнод-Эврика", "Бяцхан шинжлэх ухаанч" зэрэг өдөрлөгүүдэд 3000 гаруй сурагчийг хамруулан шинжлэх ухааны сонирхлыг нэмэгдүүлэв.			Үгүй
105	191	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-22 Дугаар 2025_22	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, сургалтын төвүүдэд мэргэжил эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжил эзэмшин хугацаат цэргийн албанаас халагдаж байгаа залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг авахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Боловсролын сайд П.Наранбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	ХХҮГ Зэвсэгт хүчний 327-р ангийн 103 хугацаат цэргийн албан хаагчдыг 3 мэргэжлээр 21 хоногийн хугацаанд мэргэжлийн сургалтад хамруулж, чадамжийн гэрчилгээ олгосон.			Үгүй